

1990-ЭЭД ОНЫ БИЧИГ ҮСЭГ СОЛИХ ХӨДӨЛГӨӨН, ТҮҮНИЙ СУРГАМЖ

Уриа¹

Товч агуулга: Эл өгүүлэлд 1990-ээд оны эхэн үед Монгол улсад өрнөсөн кирилл үсгээс монгол бичигт албан ёсоор шилжихэд бэлтгэн хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний хэрэгжилтийн талаар дүгнэлт хийж, мөн тухайн үйл явдлын талаар тэр үеийн албан хаагчдын үзэл бодлыг задлан шинжилж, тэдгээр үр дүнгээ бичиг үсэг солих талаар эрдэмтдийн дурдсан онолын зарчмуудтай холбон тайлбарлана.

Түлхүүр үг: кирилл үсэг, монгол бичиг, бичиг үсэг солихуй

1. Удиртгал

1. 1. Судалгааны зорилго: Удиртгалд дурдсанчлан Улсын Бага хурлын 1991 оны “БНМАУ-д төрийн албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах болон түүний бэлтгэлийг хангах тухай” 36 дугаар тогтоолыг дагалдан гарсан зарим баримт бичиг болон түүнийг цуцалсан Улсын Их Хурал-ын 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 66-р тогтоол зэргээс тухайн үед баримталсан бодлого тооцоо судалгаа дутмаг боловсруулагдаж, тийм ч тууштай хэрэгжиж чадаагүйг харж байна. Тэгвэл, монгол бичигт албан ёсоор шилжихээр өрнөсөн энэхүү хөдөлгөөний эрч саарсан шалтгааныг нийгмийн гишүүд хэрхэн үнэлж байгааг энэ удаа тодруулж, хожим хойшдын хэлний төлөвлөлтийн ажилд санал сэдлэг өгөх зорилгоор энэхүү өгүүллийг бичсэн болно.

1. 2. Судалгааны асуулт: 1990-ээд оны туршлага юу байв? Цаашдын үйл ажиллагаанд ямар хүчин зүйлсийг хэрхэн анхаарах вэ?

1. 3. Судалгааны арга: Бид судалгааны ажлын баримт хэрэглэгдэхүүн цуглуулахаар 2016 оны 10 дугаар сард Улаанбаатарт ажилласан юм. Энэ үед буюу 2016 онд 60-аас 80 настай бөгөөд 1990-ээд онд нутгийн захиргааны байгууллага, төрийн үйлчилгээний байгууллага, зам тээвэр, барилгын салбарт ажиллаж байсан 60 ахмадтай уулзан ярилцав. Ярилцлагын сэдэв нь “1990-ээд оны эхээр өрнөсөн кирилл үсгээс монгол бичигт албан ёсоор шилжих хөдөлгөөний тухай” байж, ярилцагчийн яриа, хариултад тус өгүүллийн 3-т дурдсан онолын шаардлагын дагуу хэрхэн үнэлж байгааг тэмдэглэн авч, шинжилгээ хийсэн юм. Статистик судалгааны аргын хувьд энэ нь цаг хийгээд зардал багагүй ордог боловч үр дүнгийн хувьд нэлээд итгэмжтэй байдаг давуу талтай болно.

¹ Тус өгүүлэл нь БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй 17ZDA316 дугаарт төслийн үр дүн болно.

2. Онолын талаас авч үзэх нь

Улс үндэстний утга зохиолын хэлэнд бичиг үсэг сонгох нь энгийн асуудал биш юм. Угсаатны зүйч, хэл шинжлэлч Ю.В.Кнорозовагийн үзэхээр бичиг үсэг нь “фасцинаци”² дамжуулдаг онцлогтой, өөрөөр хэлбэл, бидний ухамсаргүйд мэдээллийг хүргэхдээ тодорхой сэтгэл хөдлөлийн утга илэрхийлэх үүрэгтэй байдаг ажээ. Тэрбээр “Бид зүгээр л үг, тэмдгүүдийг харж байгаа бус харин яах аргагүй бидний ертөнцийг ойлгохуй, соёлын ижилсэлд нөлөөлж байдаг бичиг үсгийн гадаад хэлбэр, түүгээр дамжих ертөнцийн зураглалуудыг тогтоож байдаг” (2018:25) гэсэн юм.

Түүнээс гадна бичиг үсэг нь соёл иргэншлийн үр бүтээл юм. Тодорхой бичиг үсэг байгаа явдал нь тодорхой соёл иргэншилд харьяалагдаж буйн тэмдэг мөн. Тийм ч учраас соёл иргэншлийн нарийн төвөгтэй код болох бичиг үсэг солих явдал нь тодорхой хэмжээгээр соёл иргэншил солих явдлыг заадаг байна. Хүн төрөлхтний өнгөрсөн үеийн түүхэнд шинэ үсэг бичиг авах явдал нь ямарваа улс үндэстний эв нэгдлийг хангах, эсвэл улс төрийн зохион байгуулалтын шинэчлэлийг дархлан баталгаажуулах, тухайн төрийн шинэ соёлын илэрхийлэл болгох зорилготой байлаа. Үүний тодорхой жишээг бидний туулж ирсэн түүх бэлхнээ харуулдаг. Тухайлбал, Хубилай хаан Их Юань гүрнийг байгуулаад Пагва ламаар дөрвөлжин бичиг зохиолгон төрийн үйл хэргээ явуулах зарлиг буулгаж байсан явдал юм. XIII зууны үе гэхэд нэгэнт хэвшин тогтсон дүрэм бүхий уйгуржин монгол бичиг байсаар байтал тийнхүү дөрвөлжин бичгийг шинээр зохиолгосны шалтгааныг А.М.Позднеев нийт Юань гүрний хэмжээнд хэрэглэх бичгийн хэрэгцээтэй холбон тайлбарласан билээ (1908:167-172). Мөн, цөөнгүй хэдэн зууны уламжлалтай болоод байсан үед тод бичгийг юуны учир зохиов гэдэг дээр ч улс төрийн талыг бодолцсон хариулт давамгайлдаг. Энэ талаар Д.А.Павлов монгол бичгийн хэл нь аман ярианаасаа ихээхэн холдсон учир Зүүнгарын хаант улс байгуулагдах үед нийт ойрадын нийгмийн амьдралын олон талт хэрэгцээг хангаж чадахгүйд хүржээ. Учир иймд Зая бандида шинэ үсэг зохиох болсон байна гэж үзсэн (1962:111-112) бөгөөд Б.Ринчен (1971:293), А.В.Бадмаев (1968:14-16), Баошян (1998:173-174) нар ч мөн тийм утгатай тайлбар хийсэн байдаг.

Ю.В.Кнорозовагийн дурдсан онолыг баталсан явдал ердөө гучаад жилийн өмнө монголд дахин давтагдсан бөгөөд өнөөгийн монголчуудын дийлэнх нь үүний гэрч юм. Энэ нь 1991 онд Улсын Бага хурлаас “БНМАУ-д төрийн албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах болон түүний бэлтгэлийг хангах тухай” 36 дугаар тогтоол гаргасан явдал юм. Өөрөөр хэлбэл, улс төр, эдийн засгийн эрх чөлөөгөө олж, үндэсний ухамсар сэргэсэн ардчилсан монгол төрийн нэгэн бэлгэдэл бол Эзэн Богд Чингис хааны төрийн бичиг болж байсан монгол бичиг байлаа.

Дээрх тогтоолын дагуу Засгийн Газраас 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдөр “БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай” тогтоол гарч, мөн энэ өдөр БНМАУ-ын Ардын Боловсролын Яамны сайдын 243 дугаар буюу “Монгол бичгийн машины бичээчийн дамжаа хичээллүүлэх тухай” тушаал гарсан байна. Энэ дагуу тодорхой ажлууд төлөвлөн явуулсан боловч хэлний төлөвлөлтөд зайлшгүй анхаарах чухалтай хэдэн зарчмыг гүйцэд бодолхийлээгүйгээс болоод амжилттай хэрэгжиж чадаагүй юм. (Үүнд, төлөвлөлт хийгээд гүйцэтгэлийн аль талд хэрхэн алдсаныг иргэд хэрхэн үнэлж байгааг дараагийн хэсэгт өгүүлнэ). Тийнхүү 36 дугаар тогтоол нэгэнт биелэгдээгүй тул Улсын Их Хурал 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 66-р тогтоолоор Монгол Улсад албан хэргийг кирилл монгол үсгээр үргэлжлүүлэн хөтөлж явуулах, 1994-1995 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг албан хэрэг хөтөлж байгаа кирилл монгол үсгээр явуулах шийдвэр гаргасан билээ.

² Үгчилбэл, сэтгэл татах, дур булаах хүч гэсэн утгатай, латин хэлний ‘fascinatio’ хэмээх үгээс үүссэн нэр томьёо.

Энэ үед хэрэгжүүлсэн арга хэмжээнээс өнөөдрийн нийгэмд бичиг үсэгт хандах нэг эерэг хандлага хийгээд бичиг үсгийн боловсролд нөлөөлсөн нэг сөрөг үр дагавар үлдсэн юм. Үүний нэгдүгээрх нь, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, хот, аймаг, сум, дүүрэг, баг, хороодын засаг даргын тамга, Монгол Улсын Үндсэн хуулийн эх, улсын мөнгөн тэмдэгтийг үндэсний бичгээр дархлагдаж, аливаа гоёл чимэг ба хүндэтгэлт утгыг монгол уран бичгээр тэмдэглэн хадгалах эрмэлзэл нийгэм нийтэд нэгэнт бий болсон байна. Хоёрдугаарх нь, одоо яг идэвхтэй ажиллаж, бичиг хэрэг хөтөлж буй үеийнхний нэг хэсэг анх монгол бичгээр амлаж, удалгүй кирилл үсгээр хичээллэх завсар зөв бичих зүйн хангалттай чадвар эзэмшээгүй бөгөөд энэ нь нийгэм дэх зөв бичих зүйн холбоотой төөрөгдлийг улам дэвэргэж буй явдал ажээ.

3. Туршин судлах нь

Дай Чинша “Нийгэм хэл шинжлэлийн удиртгал” гэдэг бүтээлдээ хэлний төлөвлөлтөд зайлшгүй анхаарах зарчим хийгээд чанарыг дурдсан бөгөөд тэдгээрийг сайн бодолхийлэхгүй бол уг төлөвлөлтийн ажил аяндаа нурдаг гэжээ. Үүнд:

1. Шинжлэх ухаанч зарчим:
 1. 1. Үнэнийг эрэлхийлэх чанар
 1. 2. Динамик чанар
 1. 3. Системчилсэн чанар
 1. 4. Боломжийн чанар
2. Бодлогын чанартай зарчим:
 2. 1. Улс төрийн чанар
 2. 2. Олон нийтэч чанар
 2. 3. Онолын чанар
3. Тогтвортой чанарын зарчим:
 3. 1. Уламжлах чанар
 3. 2. Тэвчээрт чанар
 3. 3. Аажмаар ахих чанар
4. Эдийн засгийн зарчим:
 4. 1. Товч авсаархан чанар
 4. 2. Хэрэглэх боломжтой байдал
 4. 3. Ашиг тусын чанар

зэрэг болно. Эдгээр зарчим хийгээд чанарыг тус өгүүллийн удиртгалд өгүүлсэн мэдээлэл болон түүнээс хойш өрнөсөн үйл явц, өнөөгийн байдалтай жишин үзвэл тийм ч хангалттай үр дүн харагдахгүй болов уу. Харин одоо ярилцлага судалгаанд оролцогчдын саналыг хэрхэн тэмдэглэж авсныг товчоолон гаргавал:

1. Шинжлэх ухаанч зарчим буюу бичиг үсгийн хэрэглээний бодит хэрэгцээнд үндэслэсэн эсэх дээр оролцогчдын 78% нь “үгүй” буюу өөр шалтгаантай гэв. Уг үйл ажиллагааны уян хатан чанар ба системт чанар хангагдсан эсэх дээр 47% нь “хангагдсан”, 53% нь “хангагдаагүй” гэж үзжээ.

2. Бодлогын, тогтвортой чанартай зарчим дээр нийт оролцогчдын 87% нь төрийн зүгээс бэлтгэл хангасан хийгээд тууштай хэрэгжүүлсэн бол амжилттай хэрэгжих боломж байсан гэж үзсэн бол үлдсэн 13% нь ерөөс бүтэхгүй санаархал байсан гэж үзжээ.

3. Олон нийтэч чанарын хувьд 40% орчим нь уг үйл ажиллагаанд монгол бичиг бие даан суралцах хэлбэрээр, 20% гаруй нь албан ёсны курс дамжаанд суралцаж оролцсон гэсэн бол 40% орчим нь монгол бичиг сурах ямар нэгэн оролдлого хийж эхлээгүй байсан гэжээ.

4. Эдийн засгийн зарчмын хувьд нийгмийн тогтвортой хөгжилд эдийн засгийн ашиг тусыг нэмэгдүүлэх давуу талтай байсан эсэхэд тоймтой хариулсан зүйл бараг үгүй байна.

4. Хэлэлцүүлэг

Бичиг үсэг, үсгийн дүрс, зөв бичих дүрмийн шинэчлэл гэдэг нь дүрс болон зөв бичих зүйн хүрээнд хэлний хэм хэмжээг хувьсгах үзэгдэл болно. Энэ нь бүх нийтийн бичиг үсэг эзэмших явдалд хүндрэл учруулж буй бичиг үсгийн хуучин онцлогийг халах зорилгын хүрээнд явагдаж болдог байна (Орф. Реф, РГЭС). Өөрөөр хэлбэл, нийгмийн гишүүдийн харилцаа, хэрэглээнд хүндрэл учруулж буй төвөгтэй бичиг үсгийг илүү хялбар системээр солих тухай асуудал болно.

Бичиг үсгийн шинэтгэлтэй холбоотой энэхүү асуудал нь зөв бичих дүрмийг эзэмших явдлыг хөнгөвчлөх зорилгоор бичиг үсэг суралцаж буй хүмүүст зориулан хийх ажил учраас хэдийн бичиг үсэг эзэмшсэн хүмүүст сөргөөр нөлөөлөхийн (Князев С.В, Пожарицкая С.К. 2005) зэрэгцээ ирээдүй хойчийн хүмүүс өнгөрсөн үеийн бичгийн дурсгалуудтай танилцахад хүндрэл үүсгэдэг ажээ. Тийм ч учраас “орчин үеийн япончууд XIX дүгээр зууны сүүл, XX зууны эхэн үеийн уран зохиолуудаа чөлөөтэй уншиж хэдийн чадахаа больжээ” (Алпатов В.М. 2003).

Түүнчлэн, дэлхий нийтийн тухайд ямар нэгэн хэлний бичиг үсэг солих, эсвэл бичиг үсэгтэй болох нь хэлний засаглалын үр дүнд бус харин тодорхой зохион байгуулалтгүйгээр аяндаа болдог байжээ. Энэ байдал “ард түмний оюун санаа”-ны биелэл болсон утга зохиолын хэлний тухай үзэл санаа үндэстнүүдийн хувьд хүчээ авч эхэлсэн XIX-XX зуунд эрс өөрчлөгдсөн байна. Чухам энэ үеэс “тухайн хэлний хэлзүйг жигдлэн, нэг мөр болгох, хуульчлах, “хамгийн цэвэр” аялгууг сонгох, харь хэлний үгээс зайлсхийх зэргээс эхлэн хэл нь “улсын хэрэг” болжээ” (Хобсбаум Э. 1970:83-99).

Тиймээс, цаашид “Монгол хэлний тухай” хуулийн дагуу болон дөнгөж саяхан батлагдаад буй “Үндэсний бичгийн хөтөлбөр-3”-ийн зохицуулалт, үзэл санааны дагуу Монгол Улсад өрнөх хос бичгийн холбогдол бүхий үйл ажиллагаа, магадгүй монгол бичигт шилжих тухай үйл ажиллагааны төлөвлөлтийг нэг талаас онолын зарчим, чанар шаардлагад нийцүүлэх (тус өгүүллийн 2-т дурдсан), нөгөө талаас олон нийтэд чанарыг баримтлан тэдний оролцоог хангах, олон нийтийн зүгээс хэрэглэх, эзэмшихэд кирилл бичгээс илүү биш юм аа гэхэд дутуугүй хөнгөвчилсөн технологийг шийдвэрлэн хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн суурин дээр дараа дараачийн бодлого шийдвэрийг гаргах нь илүү оновчтой байна. Үүнийг нийгмийн бодит түүх, нийгмийн гишүүдийн санал үнэлэлт, тус өгүүлэлд эш татсан онолын судалгааны үр дүнгүүд харуулж байна.

5. Дүгнэлт

Хэл, бичиг үсгийн бодлого, төлөвлөлтийн талаар судалсан туршлагатай эрдэмтдийн дурдсан зүйлээс харсан ч тэр, хүн төрөлхтний, ялангуяа монголчуудын үсэг бичгийн түүхээс харсан ч тэр бичиг үсэг солих үндсэн хоёр шалтгаан байжээ. Үүнд:

1. Улс төр, нийгмийн байгуулал өөрчлөгдөхтэй холбоотой
2. Хуучин хэрэглэж буй бичиг нь бүх нийтийн бичиг үсэг эзэмших явдалд хүндрэл учруулж буй байдалтай холбоотой байна.

1990-ээд онд энэ хоёр шалтгаанаас эхнийх нь Монголд тохиосон учир кирилл үсгээс монгол бичигт шилжих боломж гарсан байна. Гэвч уг ажлыг хийсэн үйл явц нь судалгаа, төлөвлөгөө дутмаг буюу шинжлэх ухаанч зарчимгүй эхэлж, цааш бодлогын хийгээд тогтвортой байдлын зарчим баримтлаагүйгээс “түүхэн боломж”-ийг ашиглаагүй байна. Үүнийг нийгмийн гишүүдийн үзэл бодлын судалгаа давхар нотолж байна. Гэтэл түүнээс хойш гучаад жил өнгөрч, өнөөдөр болоход дээрх хоёр шалтгааны аль аль нь үгүй болжээ.

Тиймээс, ийм нөхцөл байдалд хууль заасан зохицуулалтуудыг амжилттай ажил хэрэг болгоё гэвэл тус өгүүллийн 3-р хэсэгт дурдсан чанар, шаардлагыг хангах орчныг зайлшгүй бүрдүүлэх хэрэгтэй болно.

LITERACY MOVEMENT OF 1990s AND ITS REMARK

The article deals with the measures that were taken to prepare for the official transition from Cyrillic to Mongolian script in the early 1990's, and its implementation, and also analyzes the officials' views of that period on the event. Moreover, he explains the result of his study explaining theoretical principles mentioned by the previous scholars.

Ном зүй

- Алпатов В.М. 2010. *К вопросу языковых реформ*. Вопросы филологии. №1(34). М.
- Алпатов В.М. 2003. *Япония: язык и общество*. М.
- Бадмаев А.В. 1968. *Роль Зая Пандиты в истории духовной культуры калмыцкого народа*. Элиста. Калм. кн. изд-во, с. 28.
- Баошян. 1998. *Mongᠣᠯ ᠡᠰᠢᠭᠦ ᠪᠢᠴᠢᠭ-ᠶᠢᠨ иᠦᠭᠠᠷᠠᠨ*. ÖMSKKQ. 228 tal-a.
- Дай Чинша. 2004. 戴庆厦 – 社会语言学概论. 245页
- Кнорозов Ю.В. 2018. *Избранные труды*. Сост. и отв. ред. М.Ф.Альбедиль. СПб., 594 с.
- Князев С.В., Пожарицкая С.К. 2005. *Графика и орфография*. Современный русский литературный язык. Фонетика, графика, орфография, орфоэпия. М., стр. 277-320.
- Космарский, А.А. 2003. *Смена алфавита как форма культурной модернизации*. Исторический обзор. Материалы VI Молодежной научной конференции по проблемам философии, религии, культуры Востока. СПб., с. 11-13.
- Мыльников А.С. 1999. *Картина славянского мира: взгляд из Восточной Европы*. СПб.
- Орфографическая реформа 1917-1918*. Российский гуманитарный энциклопедический словарь (2013 онд архивлагдсан).
- Павлов Д.А. 1968. *К вопросу о создании тодо бичиг*. Зап. Научн. Тр. Исслед. Ин-та, Язык, Литературы и Истории. Вып. 2. Элиста.
- Позднеев А.М. 1908. *Лекции по истории монгольской литературы*. Том. III. СПб.
- Ринчен Б. 1971. *Тод монгол бичиг, түүний соёлын ач холбогдол*. SM. Том. VIII. Уб., х. 291-295.
- Хобсбаум Э. 1998. *Нации и национализм после 1780 г*. СПб.
- Werth P. 2000. *Inorodtsy on Obrusenie: Religious Conversion, Indigenous Clergy, and the Politics of Assimilation in Late-Imperial Russia*. Казань: Ab Imperio.